



**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
САНХҮҮ, ХАНГАМЖИЙН ГАЗАР**

211238 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Самбуугийн гудамж 18, Утас: 70113755, 70111873,
70115817 Факс: (976) 70113755, (976) 70111873,
(976) 70115817, E-mail: gpdint@mongol.net

2015. 12. 31 № 9/1497
гайай _____-ны № _____-т

Г АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА
Я.ГАНБАТ ТАНАА

**Хэсгийн төлөөлөгчийн
барилгын тухай**

Улсын төсвийн 2015 оны хөрөнгө оруулалтаар танай аймгийн Цахир, Цэцэрлэг сумдад цагдаагийн хэсгийн төлөөлөгчийн байр /кобан/-ы барилга баригдаж ашиглалтад орсон.

Цахир суманд баригдсан кобаны барилгыг 77,171,548 /далан долоон сая нэг зуун далан нэгэн мянга таван зуун дөчин найм/ төгрөгөөр, Цэцэрлэг суманд баригдсан кобаны барилгыг 76,700,000 /далан зургаан сая долоон зуун мянга/ төгрөгөөр тус тус аймгийн цагдаагийн газрын балансад орлогод авч дүнг Цагдаагийн ерөнхий газрын Санхүү хангамжийн газарт ирүүлэхийг үүрэг болгож байна.

Мөн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд баригдах цагдаагийн хэсгийн төлөөлөгчийн байр /кобан/-ыг барих хуваарь гарсан.


Тус хуваарьт танай аймгийн Булган, Жавхлант сумдад хэсгийн төлөөлөгчийн байр баригдахаар тусгагдсан болно.

Иймд цагдаагийн кобаны барилгын гүйцэтгэгчийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлд заасанчлан Харьцуулсан тендер шалгаруулалт зарлаж, үнэлгээний хорооны гишүүдэд барилга баригдах сумын хэсгийн төлөөлөгч, бусад холбогдох цагдаагийн алба хаагчид, гадны төлөөлөлөөс бүрдсэн ажлын хэсэг томилон, өөрөө удирдаж сум тус бүрд нэг гүйцэтгэгч байх чиглэл баримтлан тендер шалгаруулалтыг 2016 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор зохион байгуулж ажиллах.

Шалгарсан байгууллагуудтай Цагдаагийн ерөнхий газраас өгсөн маягтын дагуу барилга угсралтын ажлын гэрээг 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор байгуулж, ажлын явцын мэдээг сар бүрийн 25-ны дотор ирүүлэх, барилгыг 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор барьж дуусгасан байх шаардлагатайг мэдэгдэж байна.

ДАРГА,
ДЭД КОМИССАР

Д.АМАРСАЙХАН



0002253